



“ХАВДРЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ” НИЙГЭМД ҮЙЛЧЛЭХ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

“Хавдрын үндэсний зөвлөл” НҮТББ нь 2014 онд байгуулагдсан бөгөөд хавдартай өвчтөнүүд, тэдгээрийн ар гэрт туслалцаа үзүүлэх, хүн амд хавдрын эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл өгөх, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус, төрийн бус байгууллага юм.

Тус байгууллага нь эрүүл мэндийн ажилтнууд, судлаачид, сайн дурын ажилтнууд, хавдрын чиглэлийн нарийн мэргэжлийн мэргэжилтэн, олон нийттэй хамтран хавдрын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, хавдартай өвчтөнүүдэд дэмжлэг үзүүлэх, хавдрын чиглэлийн судалгааны ажлуудыг гүйцэтгэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Хавдрын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамрагдалтад дэмжлэг үзүүлэх, хавдартай өвчтөнүүдийн амьдралын чанарыг дээшлүүлэх үйл ажиллагааг голлон хийж байна. Манай байгууллага сайн дурын ажилтнууд, хандив, туслалцаа үзүүлж хамтран ажилладаг хувь хүн, байгууллагууд, хамт олон зэрэг олон хүмүүсийн хөдөлмөрийн үр дүн, дэмжлэгтэйгээр үйл ажиллагааныхаа цаашдын зорилго, зорилтуудаа хэрэгжүүлдэг. Манай сайн дурын ажилтнууд, дэмжигчид нь бидний үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх ажлын салшгүй нэг хэсэг юм.

Бидний итгэл, үнэмшил

“Хавдрын үндэсний зөвлөл” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага нь бидэнд сайн дураар тусалж буй ажилтнуудын олон талт үүрэг оролцоог үнэлж, тэднийг эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн хөгжил дэвшлийн үйл ажиллагаануудад татан оролцуулахад дэмжлэг үзүүлж ажилладаг. Сайн дурын үйлс нь иргэд, хувь хүмүүсийн эв нэгдэл, итгэлцэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэхээс гадна нийгэмд чухал үүрэгтэй, ашиг тусаа өгдөг үйл ажиллагаа юм.

Сайн дурын ажилтны тодорхойлолт

Сайн дурын ажилтнууд гэж бусдад болон байгууллага, нийгэмд өөрийн хувь нэмрийг оруулахын тулд хариу нэхэлгүй, цалин хөлс шаардалгүй, өөрийнхөө хүсэл, зорилгоор цаг, мэдлэг, үр чадвараа зориулж буй хүмүүсийг хэлнэ.



Үнэт зүйлс ба зарчмууд

Хавдрын үндэсний зөвлөлөөс сайн дурын ажилтнуудыг идэвхжүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх ажлуудыг зохион байгуулж ажилладаг бөгөөд эдгээр ажлууд нь тухайн хүний цалинтай үндсэн ажлыг нь орлох зорилготой биш юм. Сайн дурын ажилтнууд нь тус зөвлөлийн үндсэн ажилтнуудын үүргийг орлон гүйцэтгэхгүй бөгөөд байгууллагын үйл ажиллагаанд туслах үүрэгтэй юм. Хавдрын үндэсний зөвлөлийн ажлын албанаас сайн дурын ажилтнуудын ажил үүргийг тодорхой болгох, тус байгууллагын үндсэн болон сайн дурын ажилтнуудын хоорондын ажлын уялдаа холбоог хангахад анхааран ажиллана.

Хавдрын үндэсний зөвлөлийн сайн дурынхны гол үнэт зүйл нь хүндлэл, итгэлцэл юм. Тус төрийн бус байгууллагаас сайн дурын ажилтнуудын оролцоо, ажиллах цаг зэргийг харилцан зөлшилцөхгүйгээр хүчээр тогтоох, гэрээ байгуулах зэргээр албан хүчээр ажиллуулахгүй болно. Түүнчлэн тус байгууллагын зүгээс сайн дурын ажилтны гүйцэтгэж буй ажилд цалин, урамшуулал олгох үүрэг хүлээгээгүй болно. Сайн дурын ажилтан нь өөрийн хүсэл сонирхлоор, ямар нэгэн албадлагагүйгээр өөрийн цагийг зохицуулж, харилцан ойлголцол, итгэлцэл дээр үндэслэж ажиллах болно.

Сайн дурын ажилтнуудын зохицуулалт

Сайн дурын ажилтнуудыг үйл ажиллагаанд оролцох, үүрэг гүйцэтгэхэд хэний удирдлаган дор ажиллахыг Хавдрын үндэсний зөвлөлийн ажилтнууд тухай бүр тодорхой заавраар хангаж ажиллана.

Сайн дурын ажилтан элсүүлэх, шалгаруулах

“Хавдрын үндэсний зөвлөл” төрийн бус байгууллагаас арьс, хүйс, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага, улс төрийн намын харьяалал, хөгжлийн бэрхшээлтэй байдал, нас үл хамааран сайн дурын ажил хийх ижил, тэгш боломжийг олгож, олон нийтэд нээлттэй ажиллах зарчмыг баримтлана. Сайн дурын ажилтнуудыг тэдний гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах үр чадвар, мэдлэгт суурилан шалгаруулна. Энэхүү сонгон шалгаруулалтын шалгуурыг тухайн ажил



үүргийг гүйцэтгэхэд зориулан боловсруулна. Сайн дурын ажил хийх боломжуудыг хүн бүр хүртээмжтэй оролцох боломжтой байхаар олон нийтэд мэдээлж байна.

Сайн дурын ажилтнууд холбоо барих хаяг, үр чадвар, сонирхол, сайн дурын ажил хийх хүсэлтэй байгаа эсэх талаарх мэдээлэл бүхий асуумжийг бүгд бөглөнө.

Шинээр элсэж байгаа сайн дурын ажилтан бүрт тус байгууллагын үйл ажиллагааны талаар болон хийж гүйцэтгэх ажил үүргээ итгэлтэйгээр гүйцэтгэхэд нь шаардлагатай холбогдох бүх мэдээллээр Хавдрын үндэсний зөвлөлийн ажилтнууд хангана.

Сургалт

Сайн дурын ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхдээ хүсэл сонирхолтой, өөртөө итгэлтэй байлгах нь Хавдрын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн чиглэл бөгөөд бөгөөд тэдэнд ажлын дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, үр чадварыг нь дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулж ажиллана. Иймээс сайн дурын ажилтан өөрийн хариуцаж байгаа ажил, чиг үүрэгт холбогдох тухайн сургалтад хамрагдах шаардлагатай.

Дэмжлэг, хяналт

Тус төрийн бус байгууллагаас сайн дурын ажилтнуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, байнга хяналт тавьж ажиллана. Сайн дурын ажилтнуудтай хамтран тэдний оролцоо болон гаргасан амжилтуудыг үнэлэх, тодорхойлох, хяналт тавих, хувь хүний сургалтын хэрэгцээг тодорхойлох зэрэг ажлуудыг Хавдрын үндэсний зөвлөл нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагаас зохион байгуулна.

Хавдрын үндэсний зөвлөл төрийн бус байгууллагаас сайн дурын ажилтнуудын хувь нэмэр, ололт амжилтыг дараах байдлаар баталгаажуулна. Үүнд:

- Сургалтанд хамрагдсан үед гэрчилгээ олгоно.
- Хандивын аян, тэмдэглэлт өдрүүд, бусад сайн дурын үйл ажиллагаанд оролцсон үед талархлын гэрчилгээ олгоно.
- Хамгийн багадаа 60 цаг эсвэл 3 сарын түрш тасралтгүй идэвхтэйгээр сайн дурын ажилд оролцсон тохиолдолд тодорхойлолт, лавлагаа бичиг хийж өгнө.



Итгэл найдвар ба үүрэг хариуцлага

Сайн дурын ажилтнууд хийж гүйцэтгэхээр тохирсон ажил үүргийг найдвартай биелүүлэх үүрэгтэй. Хэрэв ямар нэгэн шалтгааны улмаас цаашид оролцох боломжгүй болсон тохиолдолд Хавдрын үндэсний зөвлөлд мэдэгдэх шаардлагатай.

Нууцыг хадгалах

Сайн дурын ажилтнууд нь Хавдрын үндэсний зөвлөл болон тэднийг дэмжиж, хамтран ажилладаг байгууллага, бусад сайн дурын ажилтнууд, хувь хүний мэдээлэлтэй холбоотой мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй.

Ажиллахад бэрхшээлтэй нөхцөл үүсэхэд шийдвэрлэх

Тус байгууллагаас сайн дурын ажилтнуудын үзэл бодол, саналыг сонсож, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллахыг эрэлхийлнэ. Хэрэв сайн дурын ажилтнууд ажил үүргээ биелүүлэх үед бэрхшээл тулгарвал Хавдрын үндэсний зөвлөлийн ажлын албатай даруй холбогдон, зөвлөгөө дэмжлэг авна.

Үүрэг, хариуцлага

Сайн дурын ажилтнуудын үүрэг хариуцлагаа биелүүлэх нөхцлийг нь бүрдүүлэхийн тулд Хавдрын үндэсний зөвлөл төрийн бус байгууллагаас дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Сайн дурын ажилтнуудыг хүндэлж, хувь нэмрийг нь үнэлж, урамшуулна.
- Тухайн ажил үүргийг гүйцэтгэхтэй холбоотой мэдээлэл, зарцуулах хугацаа зэрэг мэдээллийг сайн дурын ажилтнуудад тодорхой өгнө.
- Ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой сургалт, түслэмж, дэмжлэгийн талаарх мэдээлэл өгнө.
- Сайн дурын ажилтнуудын гүйцэтгэсэн ажлын үр дүнгийн талаар тэдэнд эргэн мэдээлнэ.

Сайн дурын ажилтнуудын үүрэг, хариуцлага:

- Найдвартай
- Шударга байх



- Хавдрын үндэсний зөвлөлийн ажилтнууд, дэмжлэг үзүүлдэг байгууллага, хувь хүмүүс, бусад сайн дурын ажилтнуудтай хүндэтгэлтэй харьцах
- Хавдрын үндэсний зөвлөлийн олон нийтийн дундах нэр хүндийг өндөрт өргөж, мэргэжлийн хэмжээнд ажиллах
- Ялгаварлан гадуурхах, хэн нэгнийг үл тоомсорлох гэх мэт харилцааны асуудал үүсгэхгүй байх
- Сайн дурын ажил үүргээ биелүүлж чадахааргүй болсон, мөн урт хугацаагаар ажиллах боломжгүй болсон бол даруй мэдэгдэх